



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 02 өдөр

Дугаар A/96

Жаргалтхаан

Газар эзэмшүүлэх төсөл сонгон
шалгаруулалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалт явуулах журам"-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн A/91 дугаар захирамжаар зарлагдсан 10 нэгж талбар, 47 га газрыг малчдын хоршоонд эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Ганбат – Сумын Засаг даргын орлогч

Гишүүд: Г.Мөнхсайхан – Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн

Г.Түмэнжаргал – Байгаль орчны асуудал

хариуцсан мэргэжилтэн

С.Жавзандулам – Мал эмнэлгийн тасгийн дарга

Н.Ууганбаяр – Газрын даамал

2. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг чанартай зохион байгуулж, гарсан дүгнэлтийг танилцуулж ажиллахыг ажлын хэсэг (С.Ганбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ЦЭНГЭЛ

Data (D:) /A4 zahiramj/

232401233